

БАЯНХОНГОР АЙМГИЙН 2022 ОНЫ БОДЛОГЫН  
БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖИЙН  
ХЭРЭГЖИЛТ, ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,  
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН

2022 оны 02 дугаар сарын 28

Номгон

Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газрын 2022 онд бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, байгууллагын үйл ажиллагаанд Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгон хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хэрэгжилтийн үр дүнгийн талаар орон нутгийн удирдлагууд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрыг үнэн зөв, бодитой мэдээллээр хангаж, [www.unelgee.gov.mn](http://www.unelgee.gov.mn) цахим санд байршуулж, ил тод байдлыг ханган ажилласан.

Аймгийн 2022 онд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тайлагнасан бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, байгууллагын үйл ажиллагааны тайланд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, Нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ болон бусад ажил гэсэн 2 бүлэг болгон танилцуулъя.

***Нэгдүгээр бүлэг: Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тайлагнасан бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, байгууллагын үйл ажиллагааны тайланд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ***

Баянхонгор аймгийн бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, байгууллагын үйл ажиллагааны тайланд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, илтгэх хуудсыг тайлан тус бүртэй хүргүүлсэн тул энэхүү тайланд тоймлон дурдъя.

***Нэг.Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тойм:***

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд 2021 оны жилийн эцэс, 2022 оны эхний хагас жил, 2022 оны 9 сар, 2022 оны 10 сар, 2022 оны жилийн эцсийн байдлаар 5 удаа хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын цахим системээр хугацаанд нь тайлагнасан байна. Хэрэгжилтийн дэлгэрэнгүй товчоог хүснэгтэд үзүүлэв.

Д/д	Тайлагнасан хугацаа	Хэрэгжилтийн хувь	Хяналтад авсан арга хэмжээний тоо	100 хувь	90 хувь	70 хувь	50 хувь	30 хувь	0 хувь
1	2	3	4	5	6	7	8	9	10
1	2021 оны жилийн эцэс	81.18%	17	5	4	7	-	1	-
2	2022 оны эхний хагас жил	51.11%	18	2	-	3	6	7	-
3	2022 оны 9 сар	56.67%	18	2	-	6	5	5	-
4	2022 оны 10 сар	70.56%	18	3	3	6	5	1	-
5	2022 оны жилийн эцэс	66.67%	18	2	2	7	6	1	-

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж 5 удаагийн зөвлөмж өгч, аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний төсөл хэлэлцэх үеэр аймгийн Засаг дарга, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, сумдын Засаг дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга нарт Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрөөс удаашралтай байгаа 7 заалтыг хэрэгжүүлэх, төсөв батлах талаар албан бичиг хүргүүлэн ажилласны үр дүнд 2023 оны аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд 531.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий дараах ажлыг тусгасан байна. Үүнд:

-Тэрбум мод арга хэмжээнд 300.0 сая төгрөг

-Гол, горхи, булаг шанд рашааны эхийг хамгаалах, усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын зураглал хийх 10.0 сая төгрөг

-Хуучин хогийн цэгт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх 19.9 сая төгрөг

-Хог хаягдлын менежмент нэвтрүүлэх 22.0 сая төгрөг

-Эко бие засах газар - Баянхонгор сумын 300 өрхийг эко бие засах газартай болгох 180.0 сая төгрөг

**Хоёр.Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тойм:**

Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтэд 2022 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайлагнасан. Баянхонгор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 2/6 дугаар тогтоолоор батлагдсан “Баянхонгор аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн 8 бүлэг, 8 зорилго, 24 зорилт, 105 ажил арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна. Хэрэгжилтийн дундаж 87.43 хувь, дэлгэрэнгүйг зургаар үзүүлвэл:




Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн шалгуур үзүүлэлтийг Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль, тогтоомжид нийцүүлэн санхүүжилт болон бусад нөөцийг судалж, зорилтот түвшинг бодит судалгаанд үндэслэн үр дүнд суурилсан байдлаар боловсруулж, батлуулан хэрэгжүүлэх зөвлөмж өгсөн.

**Гурав.Баянхонгор аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд 2022 оны жилийн эцсийн байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тойм:**

Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасан үнэлгээ өгөх аргачлалын дагуу үнэлгээг тооцоход дунджаар 92.04 хувьтай хэрэгжиж байна. Үйл ажиллагааны хөтөлбөрийн 186 арга хэмжээний 64 хувь нь үр дүнтэй, 22 хувь нь тодорхой үр дүнд хүрсэн буюу үр дүн гарч эхэлсэн, тавьсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа, 10 хувь нь тухайн зорилт арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлж байгаа, 2 хувь нь тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатандаа, 2 хувь нь тодорхой үр дүнгүй байна.

Хэрэгжилтийг заалтын тоогоор нь авч үзвэл:

**Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны  
хөтөлбөрийн хэрэгжилт  
(2022 оны жилийн эцсийн байдлаар)**



Аймгийн Засаг даргын 2022 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, тайлангийн үр дүнг чанаржуулах зорилгоор аймгийн Засаг даргын Тамгын газраас дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна.

1.Аймгийн Засаг даргын дэргэдэх 24 агентлаг, 10 орон нутгийн өмчийн байгууллага, 20 сумын Засаг даргын Тамгын газар, бодлогын хэлтсүүдийн аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд 2022 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, заавар зөвлөмж өгч хэрэгжүүлэн ажилласан байна.

2.Аймгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим системээр (<https://bayankhongor.igovernment.mn>) Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хяналтад авах, харьяа байгууллагуудад хүргүүлэх, хэрэгжилтийг тооцох, тайлагнах, үйл ажиллагааг аймгийн хэмжээг бүрэн цахим хэлбэрт шилжүүлж, сум, агентлагийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайланг хүлээн авч явц, үр дүнг тооцох, зөвлөмж өгөх ажлыг тогтмолжуулсан байна.

3.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн арга хэмжээг сум, байгууллагуудад хуваарилан хэрэгжилтийг хангуулсан нь тодорхой үр дүнтэй ажил болж, байгууллагууд хоорондын уялдааг хангаж, бодит үр дүнг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

**Дөрөв.Аймгийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөөнд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тойм:**

Аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөг Монгол Улсын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.6-д заасны дагуу аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 6/23 дугаар тогтоолоор 7 бүлэг, 162 ажил, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан

байна. Жилийн хөгжлийн төлөвлөгөөнд аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны 9/31 дүгээр тогтоол, 2022 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 10/37 дугаар тогтоолуудаар тус тус нэмэлт, өөрчлөлт орсноор 7 бүлэг, 199 ажил, арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Аймгийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөөний 199 арга хэмжээнээс “Үр дүнтэй” буюу 100 хувьтай 150 арга хэмжээ, “Тодорхой үр дүнд хүрсэн” буюу 90 хувьтай 19 арга хэмжээ, 70 хувьтай 15 арга хэмжээ, “Эрчимжүүлэх шаардлагатай” буюу 50 хувьтай, 7 арга хэмжээ, 30 хувьтай 3 арга хэмжээ, “Үр дүнгүй” 0 хувьтай 7 арга хэмжээ байна. Аймгийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилт 90.55 хувь, 199 арга хэмжээнээс 75.4 хувь нь “Үр дүнтэй” буюу 100 хувь хэрэгжсэн, 8.5% хувь нь “Тодорхой үр дүнд хүрсэн” буюу 90 хувь хэрэгжсэн, 7.5 хувь 70 хувь хэрэгжсэн, 2 хувь нь “Эрчимжүүлэх шаардлагатай” буюу 50 хувьтай, 1.6 хувь нь “Үр дүнгүй” буюу 0 хувьтай байна.


Цаашид төлөвлөгөө, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулахдаа Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль, тогтоомжид нийцүүлэн санхүүжилт болон бусад нөөцийг судалж, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг бодит судалгаанд үндэслэн үр дүнд суурилсан байдлаар боловсруулж, батлуулан хэрэгжүүлэх зөвлөмжийг өгсөн.

**Тав.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний тойм:**

Монгол Улсын Хууль, Улсын Их Хурал болон Улсын Их Хурлын Байнгын Хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, шийдвэр, Ерөнхий сайдын албан даалгаврын хэрэгжилтийг дүгнэн тогтоол шийдвэрийг орон нутагт үр дүнтэй зохион байгуулах, хэрэгжилтийг эрчимжүүлэх, хэрэгжилт үр дүнгийн талаар аймгийн удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангах зорилгоор 2022 онд 9 удаагийн тайланг <http://new.unelgee.gov.mn> цахим системээр тайлагналаа.

Засгийн газрын хэрэг эрхлэх газраас хэрэгжиж дууссан, хугацаатай өгөгдсөн, цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон заалтуудыг нэг бүрчлэн хянаж, зөвлөсний дагуу 2022 оны 6 сард болон сарын тайлангуудад Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн системээс хасуулах хүсэлт гаргаснаар хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, тайлангийн чанарт анхаарах боломж бүрдсэн байна.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн тоо, хэрэгжилтийн хувийг сүүлийн 3 жилээр харьцуулан дараах зургаар үзүүлэв.



Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны жилийн эцэс, 2022 оны хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дэлгэрэнгүй үнэлгээг дараах хүснэгтэд нэгтгэв.

Д/д	Тайлагнасан хугацаа	Нийт				100 хувь	70 хувь	30 хувь	0 хувь	ХБ	Хэрэгжилтийн хувь	
		Шийдвэрийн тоо	Заалтын тоо	Өөрийн үнэлгээ	Дээд шатны байгууллагын үнэлгээ							
1	2	3	4	5	6	7	8	9	10	11		
1	2021 оны жилийн эцэс	100	175	72	85	9	3	6	91.06%	79.41%		
2	2022 оны I улирал	20	33	4	22	4	3	-	62.42%	62.42%		
3	2022 оны эхний хагас жил	64	162	20	23	6	2	3	74.00%	72.80%		
4	2022 оны 8 сар	45	66	21	33	3	6	3	79.35%	71.43%		
5	2022 оны 9 сар	22	36	5	22	8	1	-	63.33%	63.33%		
6	2022 оны III улирал	5	14	1	6	7			75.00%	52.14%		
7	2022 оны 10 сар	22	36	6	25	5			69.44%	69.44%		
8	2022 оны 11 сар	25	33	16	15	2			82.12%	82.12%		
9	УИХ-ын тогтоолын биелэлт	1	2	-	1	-	-	1	70.00%	-		
10	2022 оны жилийн эцэс	40	126	63	40	11	5	7	92.29%	79.24%		

**Зургаа.Гадаадын зээл тусламжаар хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тойм:**

Баянхонгор аймагт хэрэгжиж байгаа Гадаадын 9 төсөл, хөтөлбөрийн 2022 оны жилийн эцсийн хэрэгжилтийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ. Үнэлгээг хүснэгтэд нэгтгэлээ:

Д/д	Төсөл хөтөлбөр	Санхүүжүүлэгч	Хэрэгжиж буй сумдын тоо	Хэрэгжилтийн хувь
1	2	3	4	5
1	Монгол унаган байгалийн хүлцэл, тогтворжилтыг хангах нь	Даян дэлхийн байгаль орчны сан	4	100%
2	Тогтвортой ноолуур	FFEM буюу Дэлхийн байгаль орчны төлөө Францын Сан	7	100%
3	Утаагүй Баянхонгор	НҮБ-ын Хүүхдийн Сан	1	95%
4	Малчдын эрүүл мэндийг хамгаалах, малчдыг аливаа эрсдэлт өвчин эмгэгээс сэргийлэх	Австралийн элчин сайдын яамны шууд санхүүжилт	20	90%
5	Орон нутгийн иргэдэд түшиглэсэн уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн үйлчилгээ	НҮБ-ын Хүүхдийн Сан, БНСУ-ын Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага KOICA	20	98%
6	Олон нийтэд түшиглэсэн нялх бага насны хүүхдийн хоололтын зөвлөгөө	НҮБ-ийн Хүүхдийн сан	20	100%
7	Эх хүүхдийн эрүүл мэндийг сайжруулах	НҮБ-ын Хүүхдийн сан	20	96,8%
8	Best хөтөлбөр	АНУ-ын ОУ-ын Хөгжлийн агентлаг (USAID)	1	100%
9	Тогтвортой Амьжиргаа-3	Дэлхийн банк	20	100%

Цаашид гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг сум, байгууллага, бодлогын хэлтэс бүр тооцож, тайлан мэдээг нэгтгэн ажиллахыг зөвлөсөн.

**Долоо.Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тойм:**

Монгол Улсын Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээ, гэрээг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, 2022 оны жилийн эцсийн байдлаар холбогдох яамдад хүргүүлсэн. Үүнд:

1.Монгол Улсын Ерөнхий сайдтай Баянхонгор аймгийн Засаг даргын байгуулсан батламж

2.Засгийн газрын гишүүн, Шадар сайд болон Баянхонгор аймгийн Засаг даргын хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээ

3.Засгийн гишүүн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга болон Баянхонгор аймгийн Засаг даргын хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээ

4.Засгийн газрын гишүүн, Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Баянхонгор аймгийн Засаг даргын хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээ

5.Засгийн газрын гишүүн, Гадаад харилцааны сайд болон Баянхонгор аймгийн Засаг даргын хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээ

6.Засгийн газрын гишүүн, Сангийн сайд болон Баянхонгор аймгийн Засаг даргын хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээ

7.Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд болон Баянхонгор аймгийн Засаг даргын хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээ

8.Засгийн газрын гишүүн, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Баянхонгор аймгийн Засаг даргын хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээ

9.Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Баянхонгор аймгийн Засаг даргын хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээ

10.Засгийн газрын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайд болон Баянхонгор аймгийн Засаг даргын хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээ

11.Засгийн газрын гишүүн, Боловсрол, шинжлэх ухааны сайд Баянхонгор аймгийн Засаг даргын хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээ

12.Засгийн газрын гишүүн, Зам тээврийн хөгжлийн сайд Баянхонгор аймгийн Засаг даргын хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээ

13.Засгийн газрын гишүүн, Соёлын сайд Баянхонгор аймгийн Засаг даргын хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээ

14.Засгийн газрын гишүүн, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд болон Баянхонгор аймгийн Засаг даргын хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээ

15.Засгийн газрын гишүүн, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд Баянхонгор аймгийн Засаг даргын хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээ




16. Засгийн газрын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Баянхонгор аймгийн Засаг даргын хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээ

17. Засгийн газрын гишүүн, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Баянхонгор аймгийн Засаг даргын хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээ


18. Засгийн газрын гишүүн, Эрчим хүчний сайд Баянхонгор аймгийн Засаг даргын хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээ

19. Засгийн газрын гишүүн, Эрүүл мэндийн сайд Баянхонгор аймгийн Засаг даргын хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээ



**Найм.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тойм:**

Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны гүйцэтгэлийн тайланд Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагад хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам” -ын дагуу үнэлгээ хийв. Аймгийн Засаг даргын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 22 зорилт, 92 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлсэн байна. Үүнээс үр дүнтэй буюу 100% -66, тодорхой үр дүнд хүрсэн 90%-14, 70% -12 заалт, дундаж хэрэгжилт 94.57 хувьтай байна.



**Ес.Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг хангах үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тойм:**

Баянхонгор аймгийн 2022 оны жилийн хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас 18000000 (арван найман сая) төгрөг зарцуулан <http://bayanhongor.gov.mn> цахим хуудсыг шинээр хийлгэжээ.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг хэрэгжүүлж төрийн байгууллагын ил тод, нээлттэй байхаар заасан 5 бүлэг, 46 төрлийн мэдээллийг аймгийн албан ёсны [www.bayanhongor.gov.mn](http://www.bayanhongor.gov.mn) болон 20 сумын албан ёсны цахим хуудсанд байршуулан хөгжүүлж ажиллаж байна.

Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газрын Мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийн тайланд хяналт-шинжилгээ үнэлгээ хийхэд 45 үзүүлэлт бүрэн хэрэгжсэн, 1 үзүүлэлт хэрэгжих шатанд, дунджаар 99.3 хувьтай үнэлэгдсэн.

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, сумдын Засаг даргын Тамгын газрын ил тод байдлын үзүүлэлтийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийхэд 13 сумын цахим хуудас 80 хувь хүртэлх хэмжээнд мэдээлэл байршуулсан хэдий ч тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн заалтад тохирох мэдээллийг орхигдуулсан, 7 сум огт хэрэгжүүлээгүй байна.

Засаг даргын эрхлэх хүрээний 23 хэлтэс, агентлагаас 10 байгууллага албан ёсны цахим хуудастай. Эдгээр 10 байгууллага цахим хуудсандаа ил тод байдлын шалгуурын мэдээллийг 90 хувь байршуулжээ. Цахим хуудасгүй 5 байгууллага албан ёсны цахим хуудастай болохоор Үндэсний дата төвөөс домэйн нэрээ баталгаажуулах, цахим хуудасны технологийн загвар дизайнаа бүтээлгэхээр ажиллаж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагууд албан ёсны цахим хуудас хийлгэхэд санхүүгийн хувьд бэрхшээлтэй байгаа нь хуулийн хэрэгжилтийг бүрэн хангахад бэрхшээлтэй асуудал болоод байна.

Мөн <http://bayankhongor.igovernment.mn/> аймгийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим санг нэвтрүүлэн ажилласнаар бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайлан илгээх, хүлээн авах, мэдээллийг удирдах, хянах, хадгалах, ашиглах, түгээх хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны бүх шатны байгууллагуудын үйл ажиллагааг үнэлж дүгнэх ажил нээлттэй болж төрийн байгууллага, албан хаагчдын сахилга хариуцлага өссөн байна. Аймгийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санг нэвтрүүлэх ажилд аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 45.000.000 (дөчин таван сая) төгрөгийг шийдвэрлүүлэн, “Ухаалаг засаглал” төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэн, хамтран ажиллаж байна.

**Арав.Сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тойм:**

Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн 2022 оны хэрэгжилтэд Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагад хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу “Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх”, “Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах” зорилтын хүрээнд 7 үйл ажиллагааны хэрэгжилт, 26 шалгуур үзүүлэлтийн тоон мэдээлэлд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн.

“Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх”, “Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах” зорилтын 7 үйл ажиллагаа, 26 шалгуур үзүүлэлтийн 2022 оны тайланг аймгийн хэмжээнд хийгдсэн ажлыг нэгтгэн тайлагнаснаараа 2021 оны тайлангаас үр дүнтэй болсон байна.

Хяналт шинжилгээ, үнэлгээгээр “Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх”, “Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах” зорилтын 7 үйл ажиллагааны хэрэгжилтийг 100 хувь гэж дүгнэв.

Аймгийн хэмжээнд “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр” баталсан 153 байгууллага байгаа нь төрийн байгууллагууд Төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлж байгааг харуулж байна.

“Хөгжлийн зөвлөгөөн”, “Төрийн байгууллагуудын удирдах ажилтны сургалт, зөвлөгөөн”, “Төрийн албан хаагчдын сахилга, хариуцлагын зөвлөгөөн”, “Барилгын салбарын удирдах ажилтны сургалт, зөвлөгөөн”, “Хөдөө аж, ахуйн сургалт зөвлөгөөн”, “Боловсролын салбарын сургалт, зөвлөгөөн”, “Эрүүл мэндийн салбарын сургалт зөвлөгөөн” “Ойн анхдугаар чуулган” зэрэг 8 салбарын зөвлөгөөнийг зохион байгуулсан байна.

Мөн Төрийн албаны зөвлөл, Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн сургалт, семинар, бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийн тайлагналтыг чанаржуулах, цахим засаглалын хүрээнд болон эрхэлсэн, ахлах, дэс, туслах түшмэлийн мэргэшүүлэх сургалтад 33 албан хаагч, богино хугацааны зорилтот сургалтад 16, нийт 49 албан хаагчийг Удирдлагын академийн сургалтад хамруулсан байна.

Эрүүл мэндийн салбарын ажилчдын 80 хувь ур чадвар, мэргэшил дээшлүүлэх сургалтад хамрагдсан.

Нийгмийн ялгаатай салбаруудын топ түвшний удирдлага, CEO, их дээд сургуулийн тэргүүлэх зэрэгтэй эрдэмтэн судлаачид нэг дор цуглаж дэлхий нийтийн өмнө тулгамдаж буй удирдлага, хүний нөөцийн олон талт асуудлуудын талаар хэлэлцэх, туршлага хуваалцах, харилцан суралцах “Олон улсын хүний нөөцийн форум-2022 Сөүл”-д 20 сумын Засаг даргын Тамгын газрын дарга болон аймгийн Засаг даргын Тамгын газраас 4 албан хаагч оролцсон.

Бүгд Найрамдах Сингапур улсад зохион байгуулагдсан “Төрийн албаны удирдах албан тушаалтны чадавхыг бэхжүүлэх” сэдэвт сургалтад аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Д.Энхжаргал хамрагдсан байна.

Аймгийн хэмжээнд 2022 онд төрийн албаны нэр хүнд дээшилж, төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааны талаарх иргэдийн ойлголт,

мэдлэг нэмэгдсэн, төрийн албаны салбар зөвлөлд төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбох өргөдөл, гомдлын тоо 33 хувиар буурсан байна.

Тайлант онд болзол, шаардлагыг хангасан 37 төрийн жинхэнэ албан хаагчдын зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгосон.

Аймгийн хэмжээнд төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах чиглэлээр 2.071.7 сая төгрөгийн санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэж, 1 сумын Засаг даргын Тамгын газрын барилга, 3 байгууллагын компьютер, тоног төхөөрөмж, 20 сумын 40 багт мотоцикл, 3 сумд авто машин, 3 байгууллагад авто машин, Нэгдсэн эмнэлгийн Яаралтай тусламжийн тасагт 160 сая төгрөгийн өртөг бүхий LH8800 загварын амьсгалын аппаратыг шийдвэрлэсэн байна.

Тайлант онд төрийн албан хаагчид Төрийн албаны тухай хуулийн 59 дүгээр зүйлд заасан нөхөх төлбөр 102.6 сая төгрөг, Төрийн албаны тухай хуулийн 60 дугаар зүйлд заасан тусламжид 195.6 сая төгрөг, Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлд заасан нийтлэг баталгаанд 1.703.7 сая төгрөгийг зарцуулсан байна.

#### Арван нэг. Хэрэглэгчийн үнэлгээний тойм:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс 2022 оны 11 дүгээр сард Баянхонгор аймгийн төвийн 10 багийн 1000 иргэн, 20 сумын багийн төлөөлөл 200 иргэнээс төрийн үйлчилгээний сэтгэл ханамжийн судалгааг авч, нэгтгэсэн байна. Хамрагдсан иргэдийн 41.8 хувь хангалттай гэсэн үнэлгээ өгсөн байна. Үнэлгээний асуулгын хувийг доорх хүснэгтээр үзүүлэв.

№	Үнэлгээний асуулга	Авбал зохих хувь	Авсан хувь	Нийт үнэлгээ
1	2	3	4	5
1	Аймаг орон нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний чанар хүртээмж хэр байна вэ?	100	38.9	41.8
2	Аймгийн Засаг даргын Тамгын газрын ил тод байдлыг та хэрхэн үнэлж байна вэ?	100	52.3	
3	Төрийн үйлчилгээг үнэлэх, хянахад олон нийт хэр оролцдог гэж та бодож байна вэ?	100	10.3	
4	Аймгийн цахим хуудсыг та мэдэх үү	100	62.8	
5	Аймгийн албан ёсны <a href="https://bayanhongor.gov.mn/">https://bayanhongor.gov.mn/</a> цахим хуудсын мэдээллийн агуулга, чанар шинэчлэлт таны хэрэгцээг хангаж чадаж байна уу?	100	56.0	
6	Аймгийн албан ёсны <a href="https://bayanhongor.gov.mn/">https://bayanhongor.gov.mn/</a> цахим хуудаст төрийн үйлчилгээнд мөрдөж буй дүрэм журам, иргэдийн бүрдүүлбэл зохих материал, үйлчилгээг ямар хугацаанд үзүүлэх талаарх мэдээллүүд /тусгай зөвшөөрөл авахад гэх мэт/ хангалттай байж чадаж байна уу?	100	33.4	
7	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан бодлого, хэрэгжүүлж буй үйл ажиллагааны хэрэгжилтийг та үнэлнэ үү?	100	61.6	
8	Аймаг орон нутагт иргэдийн оролцоо, Иргэний нийгмийн	100	30.4	

1	2	3	4	
	байгууллага, төрийн байгууллагын ажлын уялдаа холбоо хэр байна вэ?			
9	Төрийн байгууллагуудын албан тушаалтны ёс зүй, үүрэг хариуцлага хүнд суртал, мэдлэг ур чадвар хэр байна вэ?	100	30.8	

**Арван хоёр.Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээг үнэлэх шалгуур үзүүлэлтийг биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тойм:**

Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн хүрээнд сум, агентлагуудын үйл ажиллагааны тайлан, шалгуур үзүүлэлтийн дагуу тоон мэдээлэлд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хэсгийг 4 чиглэлд "Сумдын Засаг даргын Тамгын газар, төсөвт байгууллагуудын 2022 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх тухай" удирдамжийн дагуу сумдад ажиллан "Тэрбум мод", "Хог хаягдлын менежментийг сайжруулах" "Цахим засаглал"-ын чиглэлээр хийсэн ажлын тайланг бодит байдал дээр нь тулган баталгаажуулж үнэлэлт дүгнэлт өгч ажилласан.

"Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг үнэлж, зөвлөмж боловсруулах ажлын хэсгийг мэргэжлийн хүмүүсийг оролцуулан аймгийн Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн А/78 дугаар захирамжаар байгуулан "Тэрбум мод" "Хог хаягдал", "Цахим шилжилт", зэрэг тэргүүлэх чиглэлийн тайланг үнэлж, дүгнэлээ.

Баянхонгор аймаг 2022 онд 500,000 ширхэг модыг тарьж ургалтын хувийг 70 хувьд хүргэх зорилт тавьсан бөгөөд 522,808 ширхэг мод, бут, сөөгийг тарьж ургалтын хувь 70,64 хувьд хүрсэн байна. Хяналт шинжилгээ, үнэлгээгээр Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний 2022 оны хэрэгжилтийг "Үр дүнтэй буюу" 100 хувь гэж дүгнэв.

Баянхонгор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 131 дүгээр тогтоолоор "Хог хаягдлын менежментийг сайжруулах аймгийн хөтөлбөр"-ийг 4 бүлэг 26 зорилттой батлан, хэрэгжүүлсэн байна. Хөтөлбөрийн хэрэгжилт 70,64 хувьтай байна.

"Цахим шилжилт"-ийн хэрэгжилт 90 хувийн гүйцэтгэлтэй гэж үзэв.

**Арван гурав. Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтэд хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээний тойм:**

Эдийн Засаг, нийгмийн хөгжлийн 44 шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт 82,9% - тай байна. Үүнээс ажилгүйдлийн түвшин 7,0 болгохоор зорилт тавьж, 13,6 болж

өссөн тул 0% гэж үнэллээ, PM2.5 тоосонцорын жилийн дундаж агууламж, 1.000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэглийн түвшин өссөн тул 0% гэж үнэллээ.

Жендэрийн тэгш бус байдлын индексийг Жендэрийн үндэсний хорооноос 2023 оны 05 дугаар сард эцэслэн гаргадаг тул үнэлгээнд тооцоогүй. Оюутан цэрэг хөтөлбөр улсын хэмжээнд хэрэгжээгүй тул үнэлгээнээс хасч тооцов.

**Хоёрдугаар бүлэг: Нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ болон бусад ажил**

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг сумын Засаг даргын Тамгын газар, орон нутгийн өмчийн байгууллагуудын 2022 үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмж өгч ажилласан ба албан хаагчдыг чадавхижуулах, хяналт-шинжилгээ, үнэлгээний ил тод байдлыг хангах чиглэлээр дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1.Аймгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний <http://bayankhongor.igovernment.mn> цахим системээр дараах 14 төрлийн тайланг 20 сум, 24 агентлаг, 10 орон нутгийн өмчийн болон босоо удирдлагатай төрийн өмчийн байгууллага, аймгийн Засаг даргын Тамгын газрын 7 нэгжээс авах нөхцөлийг бүрдүүлж, давхардсан тоогоор 663 байгууллага, нэгжид бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийн 18013 заалтыг хуваарилж, 33603 заалтын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмж өгч ажиллалаа. Үүнд:

Д/д	Тайлагнасан баримт бичгийн нэр	Тайлагнасан байгууллага, АЗДТГ--ын тоо	Хяналтад байгаа		Үнэлгээ хийсэн давтамж
			Шийдвэрийн тоо	Заалтын давхардсан дүн/тоо	
1	2	3	4	5	6
1	Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	21	1	68	3
2	Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	34	1	240	1
3	Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	59	1	629	2
4	Аймгийг хөгжүүлэх жилийн төлөвлөгөө	56	1	771	2
5	Сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	20	20	2016	2
6	Дэд хөтөлбөр (хяналтад байгаа шийдвэр, заалт давхардсан тоогоор)	60	322	1212	2
7	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр (хяналтад байгаа шийдвэр, заалт давхардсан тоогоор)	60	3001	6406	6
8	Аймгийн Иргэдийн	38	368	372	2

1	2	3	4	5	6
	төлөөлөгчдийн хурлын тогтоол, шийдвэр (хяналтад байгаа шийдвэр, заалт давхардсан тоогоор)				
9	Аймгийн Засаг даргын захирамж, албан даалгавар (хяналтад байгаа шийдвэр, заалт давхардсан тоогоор)	61	1757	5499	2
10	Засгийн газрын зарим чиг үүргийн орон нутагт хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	52	18	976	2
11	Аймгийн Засаг дарга-Сумын Засаг даргатай байгуулсан гэрээ	20	20	1840	2
12	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт	74	54	10712	2
13	Сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр	54	1	378	2
14	Ил тод байдлын шалгуур	54	1	2484	2
	Дүн	663	5566	33603	32

Мэдээллийн системээр сум, агентлаг, орон нутгийн өмчийн байгууллагын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагааны тайланг 2022 оны эхний хагас жил, жилийн эцсийн байдлаар тус тус хүлээн авч, үнэлж, дүгнэх үйл ажиллагааг тогтмолжуулсан. Мөн хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн тайланг 2022 оны 9 дүгээр сараас эхлэн сар бүр аймгийн цахим мэдээллийн системээр авч, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ажилласан.

Дээрх цахим тайлангаас гадна харьяа байгууллага, сумдаас ирүүлсэн Монгол Улсын Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээг үнэлэх шалгуур үзүүлэлтийн биелэлт, аймгийн Засаг даргын 2022 оны А/286 дугаар захирамжаар батлагдсан “Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, нутгийн захиргааны болон орон нутгийн өмчит байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журмын 15 дугаар хавсралтаар батлагдсан байгууллага, нэгжийн тэргүүлэх ач холбогдолтой арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлт, Хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилт зэрэг тайланг цаасаар хүлээн авч үнэлж ажиллалаа. Эдгээр 3 тайлан одоогоор цахим системд ороогүй болно.



Сумдын Орон нутгийн хөгжлийн сангийн удирдлагын мэдээллийн системд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, 20 сумд үйл ажиллагааг сайжруулах зөвлөмж өгсөн.

2.Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагууд, сумдын Засаг даргын Тамгын газар, орон нутгийн өмчийн болон босоо удирдлагатай төрийн өмчийн нийт 54 байгууллагуудад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж тогтоол шийдвэрийн хэрэгжилт, бодлого төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, албан хаагчдын сахилга, хариуцлагыг сайжруулж, бодлогын зөвлөгөө, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангах зорилгоор зөвлөн туслах үйлчилгээг 2022 оны 5, 6 дугаар сард 1 удаа, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг 2023 оны 1, 2 дугаар сард 1 удаа тус тус сум, байгууллагууд дээр очиж хийсэн. Байгууллагуудын 2022 оны эхний хагас жил, жилийн эцсийн бодлогын баримт бичиг, хууль, тогтоомж, тогтоол шийдвэр, байгууллагын үйл ажиллагааны тайланд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний зөвлөмж, тайланг байгууллага тус бүрт 2 удаа, нийт 108 зөвлөмж хүргүүлэн ажилласан.

2022 оны эхний хагас жилийн байдлаар тайлан ирүүлээгүй Эрүүл мэндийн даатгалын хэлтэс, хангалтгүй тайлан ирүүлсэн Соёл, урлагийн газар, Бөмбөгөр, Баянлиг, Галуут сумд, Баянхонгор эрчим хүч ХХК, Жаргалтай амьдрал сэтгэц, нийгмийн сэргээн засах төв, Автотээврийн үндэсний төвийн Баянхонгор аймаг дахь салбар, Бөөнцагаан-Орон нуурын сав газрын захиргаа зэрэг байгууллагуудад ажил эрчимжүүлэх хугацаатай үүргийг өгсний үр дүнд үйл ажиллагааны тайланг хугацаанд нь тайлагнадаг болсон.



Нутгийн захиргааны байгууллагуудын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, байгууллагын 2022 оны үйл ажиллагаанд хийсэн Хяналт-шинжилгээний нэгдсэн дүнг 2023 оны 3 дугаар сарын сүүлчээр зохион байгуулагдах “Удирдах ажилтны хариуцлагын зөвлөгөөн”-д хэлэлцүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

3.Хяналт шинжилгээ, үнэлгээнээс гарсан нэгдсэн дүгнэлт зөвлөмжийг аймгийн Засаг даргын Тамгын газрын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, “Бодлогын баримт бичгийг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн батлуулах тухай” аймгийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр албан даалгаврыг гарган хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Тус албан даалгаврын хүрээнд бодлогын баримт бичгүүдийн суурь түвшин, хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 119 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөгжлийн бодлого

төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах нийтлэг журам” -д нийцүүлэн батлуулах ажлыг зохион байгуулж, аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлууллаа.

4.Төрийн болон орон нутгийн бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, төрийн албан хаагчдын үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх, төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах талаар аймгийн Засаг дарга, аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлаг, сумдын Засаг даргын Тамгын газарт 2022 онд нийт 182 зөвлөмжийг хүргүүлэн хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.

5.Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, бодлого төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл үр дүнг нэмэгдүүлэх, цахим системийн ашиглалтыг сайжруулах зорилгоор 2022 оны 04 дүгээр сарын 21, 22-ны өдрүүдэд “Цахим системийн ашиглалтыг сайжруулах нь”, 2022 оны 11 дүгээр сарын 16, 17, 18-ны өдрүүдэд “Бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийн хэрэгжилт, үйл ажиллагааны тайланд анхаарах асуудал” сэдвээр 2 удаагийн сургалтыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагийн дарга нар болон хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд, сумын Засаг даргын Тамгын газрын дарга болон Хууль эрх зүй, дотоод ажил хариуцсан мэргэжилтнүүд, орон нутгийн өмчийн байгууллагын дарга нар болон цахим систем хариуцах ажилтнууд зэрэг давхардсан тоогоор 183 албан хаагчид хийв.





6.Хяналт-шинжилгээ, үнэлгээний нээлттэй ил тод байдлыг хангаж, bayanhongor.gov.mn цахим хуудас болон “Нээлттэй засаг-Нэг Баянхонгор хуудсаар тухай бүр мэдээллийг олон нийтэд цацсан.

**Нээлттэй засаг - Нэг Баянхонгор**  
Хоёрдугаар сарын 27

2021 ОНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ДҮНГЭЭР ТЭРГҮҮНИЙ БАЙГУУЛЛАГААР С.РЭНЦЭНДАГВА ДАРГАТАЙ ТАТВАРЫН ХЭЛТЭС, ТЭРГҮҮНИЙ СУМААР Т.ЭРДЭНЭБАТ ДАРГАТАЙ ӨЛЗИЙТ СУМ ТУС ТУС ШАЛГАРЛАА

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, аймгийн Засаг даргын 2021 оны А/142 дугаар захирамжаар батлагдсан “Бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын дагуу явуулсан хяналт, шинжилгээ, үнэлгээний эцсийн дүнг Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газраас гаргажээ.

Сумдын үйл ажиллагаанд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээ. Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2021 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний дүнг аймгийн удирдах амжилтын зөвлөгөөний үеэр ЗДТГ-ын дарга Д.Энжаргал танилцуулав.

Сумдын ЗДТГ-ын 2021 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт шинжилгээ үнэлгээний дүнгээр:

- 83,34 хувь буюу 4,17 оноогоор “Тэргүүний сум”-аар Т.Эрдэнэбат даргатай Өлзийт сум шалгарч 5,0 сая.

**Нээлттэй засаг - Нэг Баянхонгор**  
11-р сарын 16

Баянхонгор : ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ МЭДЭЭЛЛИЙН ЦАХИМ САНГ НЭВТРҮҮЛСЭН ГУРАВ ДАХЬ АЙМАГ БОЛЛО

Баянхонгор аймаг нь улсын болон орон нутгийн хөгжлийн бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх цахим системийг 2021 оны 4 дүгээр улирлаас эхлэн үйл ажиллагаа-даа ашиглаж эхлээд байна.

Энэхүү системийг Засгийн газрын хэрэг эрхлэх газар 2013 оноос нэвтрүүлсэн бөгөөд Төв, Дорноговь аймгуудын дараа ... [Цааш үзэх](#)



Монгол Улсын Засгийн газрын “Дүгнэлт, зөвлөмж хүргүүлэх тухай” 2022 оны ХЭГ/1645 дугаар албан бичгээр ирсэн зөвлөмж, дүгнэлтийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулан төлөвлөгөөг 100 хувьтай хэрэгжүүллээ.

### Дүгнэлт

Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газраас 2022 онд харьяа байгууллага, нэгжийг мэргэжил арга зүйн сургалт, зөвлөгөө, зөвлөмжөөр хангаж, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээг цахимаар болон бусад хэлбэрээр хийсний үр дүнд Нутгийн захиргааны байгууллагуудын ил тод байдал нэмэгдэж, төрийн албан

хаагчдын үүрэг хариуцлага, байгууллага хоорондын уялдаа холбоо сайжирч, цаг хугацааны болон төсвийн хэмнэлт бий болсон.

Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны үйл ажиллагааны үр дүнг хавсаргав.

ХЯНАСАН:  
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Д.МӨНХСАЙХАН

ТАЙЛАН БИЧСЭН:  
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ  
ХЭЛТСИЙН ДАРГА

Л.МАНДАЛ



**БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН**

Үзүүлэлт		Хувь	Жин	Оноо
1	2	3	4	5
Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт	92.29	0.5	
	2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	66.67		
	3. Аймаг, нийслэлийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	90.55		
	4. Аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	92.04		
	5. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт	82.9		
Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	1. Монгол Улсын Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутаг төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт	97.46	0.15	
	2. Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт	94.57		
	3. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт	100		
Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	1. Байгууллагын ил тод байдал	99.3	0.2	
	2. Шилэн дансны хөтлөлт	100		
	3. Шударга байдлын түвшин	-		
	4. Хэрэглэгчийн үнэлгээ	100		
Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн үнэлгээ	Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээг үнэлэх шалгуур үзүүлэлтийн биелэлт	86.88	0.15	
Ерөнхий үнэлгээ:		91.89	1	